



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дугаар сарын 06

Дугаар 01

Улаанбаатар хот

### УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН I ХУРАЛДААН

Улсын онцгой комиссын хуралдаан 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 14.00 цагт Төрийн ордон дахь “Монгол Улсын Шадар сайдын хурлын өрөөн”-д хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Томуу томуу төст өвчний нөхцөл байдал болон зарим улс оронд дэгдсэн метапневмовирус (hMPV)-ын тархалт, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, бэлэн байдлын талаар

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан

2. Сайжруулсан шахмал түлшний стандартыг өөрчлөх ажлын явцын талаар

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Одонтуяа

3. Бусад

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

**Нэг. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн  
Т.Мөнхсайханд:**

- 1.1. Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны үйл ажиллагааг идэвхижүүлж метапневмовирус (hMPV) болон бусад төрлийн томуу томуу төст өвчний халдвартын дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг тодотгох;
- 1.2. Халдварт өвчний эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгааны ажлыг тогтмол хийж, эрүүл мэндийн салбарын бэлтгэл бэлэн байдлыг хангах;
- 1.3. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад тандалт, хариу арга хэмжээ, эмнэлгийн тусlamж, лабораторийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх, танхимын болон цахим сургалтыг тогтмол зохион байгуулах;
- 1.4. Эрсдэлт бүлгийн хүн ам ялангуяа бага насы хүүхдүүд, өндөр настнууд, томуу, томуу төст өвчний шинж тэмдэгтэй хүн амын дунд вирус судлалын тандалтыг эрчимжүүлэх;
- 1.5. Хүүхдийн тасгийн болон эрчимт эмчилгээний тусlamж үйлчилгээ, лабораторийн урвалж, оношуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх ;
- 1.6. Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн эмнэлгийн тусlamж үйлчилгээг сайжруулах, хяналтыг идэвхжүүлэх;

**Хоёр. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн  
Т.Мөнхсайхан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын  
онцгой комиссын гишүүн Х.Батжаргал нарт:**

- 2.1. Ерөнхий боловсролын сургуулийн улирлын амралт дуусаж хүн амын дунд хөдөлгөөний эрчим нэмэгдэхтэй зэрэгцэн томуу, томуу төст өвчний дэгдэлт өсөж эмнэлгийн ачаалал нэмэгдэх, сургалтын хэвийн үйл ажиллагаа алдагдахаас сэргийлж эрсдэлийн үнэлгээг хийж, үнэлгээнд тулгуурлан урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;

**Гурав. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:**

- 3.1. Халдварт өвчний тандалт, хариу арга хэмжээг идэвхижүүлэх, бэлэн байдлыг хангах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж ажиллах;
- 3.2. Орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийж, халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг Эрүүл мэндийн яам болон бусад мэргэжлийн байгууллагын удирдамжийн дагуу бүх шатанд авч хэрэгжүүлэх;

**Дөрөв. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн  
Т.Мөнхсайхан, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын  
дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Ганзуул нарт:**

4.1. Томуу, томуу төст өвчин болон метапневмовирус (hMPV) зэрэг халдварт өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох зөвлөмж, сээрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол өгөх;

**Тав. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Агаар орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга С.Одонтуяад:**

5.1. Сайжруулсан шахмал түлшний стандартыг олон улсын жишигт нийцүүлэн батлуулах, түүнд шаардлагатай тооцоо судалгааг яаралтай хийж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх;

**Зургаа. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар нарт:**

6.1. Тагнуул, Цагдаагийн байгууллагын хяналттайгаар сайжруулсан шахмал түлшний үйлдвэр, агуулах, борлуулах цэг болон айл өрхийн хэрэглээнд байгаа сайжруулсан шахмал түлш, мидлинг, барьцалдуулагч зэрэг түүхий эд тус бүрээс дээж авч Япон, Бүгд Найрамдах Солонгос улсын лабораторийн шинжилгээнд явуулж, үр дүнг 2025 оны 01 дүгээр сард багтааж Улсын онцгой комисст танилцуулах;

**Долоо. Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал П.Одонбаатар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Т.Сүхболд нарт:**

7.1. Шахмал түлшний үйлдвэр, агуулах, борлуулах цэг болон айл өрхийн хэрэглээнд байгаа түлш, мидлинг, барьцалдуулагч зэрэг түүхий эдээс дээж авч Япон, Бүгд Найрамдах Солонгос Улсын лабораторийн шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хяналт тавих, явц, үр дүнг 2025 оны 1 дүгээр сард багтааж Улсын онцгой комисст танилцуулах;

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

